

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2022 оны 11 дүгээр сар/**

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлж байна.


2022 оны хүйтний улирлын 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 10 мкг/м³-ээр буюу 15%-иар, PM10 тоосонцор 33 мкг/м³-ээр буюу 25%-иар, хүхэрлэг хий (SO₂) нь 7 мкг/м³-ээр буюу 8%-иар бага байна. Харин азотын давхар исэл (NO₂) нь 2 мкг/м³-ээр буюу 4%-иар их байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2021 оны 11 дүгээр сар	2022 оны 11 дүгээр сар
PM2.5 тоосонцор	50	65	55↓
PM10 тоосонцор	100	130	97↓
Азотын давхар исэл, NO ₂	50	49	51↔
Хүхэрлэг хий, SO ₂	50	92	85↓

* ↓ бага; ↑ их; ↔ ойролцоо түвшинд /±5%/.

Улаанбаатар хотын сүүлийн 6 жил буюу 2017-2022 оны 11 дүгээр сарын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт үзүүлж байна.


PM2.5 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцор 2022 оны 11 дүгээр сарын дундаж агууламж 55 мкг/м³ байна. 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 15%-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.1 дахин их байна. (Зураг 1).


PM10 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2022 оны 11 дүгээр сарын дундаж агууламж 97 мкг/м³ байна. 2021 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад 25%-иар бага. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй. (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Азотын давхар ислийн 2022 оны 11 дүгээр сарын дундаж агууламж 51 мкг/м³ байна. 2021 оны мөн үетэй харьцуулахад 4%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1 дахин их байна. (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2017-2022 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2022 оны 11 дүгээр сарын дундаж агууламж 85 мкг/м^3 байна. 2021 оны мөн үетэй харьцуулахад 8%-иар бага. Харин агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1.7 дахин их байна. (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС